

ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР: (2005-2017)

Гамшгаас хамгаалах сургалт сурталчилгааны талаар.

Ази, номхон далайн бүсийн газар хөдлөлтийн хор уршгийг арилгах олон улсын сургалт, дадлага сургууль (INSARAG)

“Гамшгаас гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”-ний 2.15 дахь заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан НҮБ-ын Хүмүүнлэгийн хэргийг зохицуулах газар, Эрэн хайх, авран туслах олон улсын зөвлөлдөх бүлэгтэй хамтран “Ази-Номхон далайн бүсийн газар хөдлөлтийн хор уршгийг арилгах” олон улсын сургалт, дадлага сургуулийг 2007, 2015 онд тус тус Улаанбаатар хотноо зохион байгуулсан.

Энэхүү олон улсын сургалт, дадлага сургууль нь Монгол Улсад газар хөдлөлтийн томоохон аюул тохиолдож, ихээхэн хэмжээний хохирол учруулж, хор уршгийг арилгах үндэсний хүч хэрэгслийн чадавх хүрэлцэхгүй тохиолдолд гадаад улс орон, олон улсын байгууллагаас хүмүүнлэгийн тусламж хүсэх, тусламжийг хилээр шуурхай нэвтрүүлэх, гамшгийн голомтод үндэсний гамшигтай тэмцэх байгууллага, аврах багуудтай хамтран ажиллах, үйл ажиллагаа тогтворжсоны дараа буцан гарах цогц арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулахад чиглэгдсэн.

Сургалт, дадлага сургуульд Европ, Америк, Ази, Номхон далайн улс орнууд, НҮБ-ын Хүмүүнлэгийн хэргийг зохицуулах газар, Монгол Улсын Засгийн газар, яам, агентлаг, гамшгаас хамгаалах албад, аж ахуйн нэгж, байгууллага, Монгол Улс дахь Олон улсын болон төрийн бус байгууллагуудын төлөөлөл оролцсон.

“Говийн чоно” олон улсын сургалт, дадлага сургууль

Болзошгүй гамшиг, аюулт үзэгдэл, ослын хор уршгийг арилгах, гамшгаас хамгаалах төлөвлөлтийг сайжруулах, улс болон орон нутгийн албад, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийг бодит нөхцөл, цагийн байдалд уялдуулан ажиллуулах, тэдний харилцан хамтын ажиллагааг жигдрүүлэх, улс орны гамшгаас хамгаалах бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэхэд чухал үр дүнгээ өгөх “Говийн чоно” гамшгийн хор уршгийг арилгах, туршлага солилцох олон улсын сургалт, дадлага сургуулийг АНУ-ын Элчин сайдын яам, Аляскийн үндэсний гвард, Номхон далайн армитай хамтран 6 удаа зохион байгуулаад байна. Энэхүү сургалт, дадлага сургуулийн зорилго, чиглэл, хамрах хүрээ өргөжин тэлж, хот суурин газраас улс, бүс нутгийн түвшинд хүрч, нэг агуулгаас хэд хэдэн агуулгыг хамарч, олон улсын оролцоог хангасан үндэсний брэнд сургууль болтол хөгжүүлээд байна.

2008 онд “Газар хөдлөлтийн гамшгийн үеийн хот, суурин дахь эрэн хайх, аврах ажиллагаа”, 2009 онд “Төмөр замын томоохон ослын үеийн эрэн хайх, аврах, сэргээн босгох ажиллагаа”, 2010 онд “Уул уурхайн томоохон ослын үеийн эрэн хайх аврах ажиллагаа”, 2015 онд “Улаанбаатар хотод газар хөдлөлтийн гамшгийн аюул тохиолдсон үеийн эрэн хайх аврах, сэргээн босгох ажиллагаа”, 2016 онд “Газар хөдлөлтийн гамшгийн үед Монгол Улсын Засгийн газар, орон нутгийн удирдлагын харилцан ажиллагаа”, 2017 онд “Гамшгийн үе дэх бүс нутгийн удирдлага, харилцан ажиллагаа” сэдвээр тус тус зохион байгуулсан.

Сургалт, дадлага сургуулийн хүрээнд бодит нөхцөл байдалд ойртуулан боловсруулсан цагийн байдал дээр оролцогчдыг бүлгээр ажиллуулах хэлбэрээр танхимын сургалтыг, танхимын сургалтаар олсон мэдлэг, чадварыг батжуулах зорилгоор биеэр гүйцэтгэх дадлага сургуулийг тус тус явуулж, цаашид хот, суурин газар, аймаг, бүс, улсын түвшинд гамшгаас хамгаалах үйл ажиллагааг төгөлдөржүүлэхэд анхаарч ажиллах чиглэлүүдээр зөвлөмж гаргаж, дараагийн сургуулийн зорилго, чиглэл, хамрах хүрээгээ тодорхойлдог.

Энэхүү 6 удаагийн сургалт, дадлага сургуульд Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Баянхонгор, Өвөрхангай, Говьсүмбэр аймгийн Онцгой комисс, улсын болон орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиас давхардсан тоогоор 5000 ажилтан, албан хаагч, 35.000 иргэн, Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын болон төрийн бус байгууллагуудаас 250 хүн оролцсон байна. Мөн Монгол Улс, АНУ-ын оролцогчдоос гадна Япон, Непаль, Өмнөд Солонгос, Канад, Унгар, Бангладеш зэрэг улс орнуудаас төлөөлөгч оролцсон.

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль

Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, хөтөлбөр, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулах хүрээнд “Гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль”- ийг жил бүр 4-5 аймагт зохион байгуулж гамшгийн менежментийн мэдлэгийг төрийн байгууллага, хуулийн этгээдийн удирдах албан тушаалтнуудад таниулах, иргэд олон нийтийг байгаль, цаг уурын аюулт үзэгдэл, үйлдвэр технологийн ослоос өөрийгөө хамгаалах, бусдад туслах үйл ажиллагаанд сургаж, дадлагажуулах ажлыг зохион байгуулж ирсэн. Үүнд:

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийг 21 аймагт зохион байгуулсан.

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн үеэр аюулт үзэгдэл, ослоос хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, байгаль орчин, мал амьтныг хамгаалах, эрэн хайх, аврах, хор уршгийг арилгах, сэргээн босгох, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх үйл ажиллагаанд хүн амыг сурган дадлагажуулахад нийт 420.000 гаруй иргэн, алба, мэргэжлийн ангийн хүч хэрэгслийн харилцан ажиллагааг жигдрүүлэх, бэлтгэл, бэлэн байдлыг дээшлүүлэх үйл ажиллагаанд гамшгаас хамгаалах орон нутгийн алба 252, сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги 290, тусгай зориулалтын мэргэжлийн анги 672, тэдгээрийн томилгоот 51.900 гаруй ажилтан, албан хаагч, 3840 автомашин, 103.600 төрлийн багаж, техник хэрэгсэлтэй оролцсон байна.

Гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд аймаг, сум, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн нийт 3500 гаруй гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

2013 оноос гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн бодлого, хөтөлбөрийн хүрээнд байгалийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой ослын хор уршгаас хүн амыг хамгаалах, тэднийг бэлэн байлгах зорилгоор сум нүүлгэн шилжүүлэх дадлага, сургуулийг зохион байгуулж байна. Сум нүүлгэн шилжүүлэх дадлага, сургуулийг Булган аймгийн Орхон, Баянхонгор аймгийн Баян-Овоо, Орхон аймгийн Жаргалант, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ, Говь-Алтай аймгийн Тайшир, Баян-Өлгий аймгийн Бугат, Дорноговь аймгийн Айраг зэрэг 7 суманд зохион байгуулж, 4200 гаруй хүн амыг аюулгүй байршилд шилжүүлж, тэднийг амьдралын наад захын хэрэгцээ- (орон байр, ус, хүнс, дулаан хувцас, эрүүл мэнд, боловсрол, аюулгүй байдал)-гээр хангах үйл ажиллагаанд тухайн сум, багийн удирдлага, иргэдийн үүрэг оролцоог нь таниулж ажиллаа.

Мөн 2015 оноос гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд аймгийн төвийн нийт иргэдийг нүүн шилжүүлэх дадлага, сургуулийг зохион байгуулж эхэлсэн. Томоохон суурин газарт үүссэн газар хөдлөлт, химийн бодисын хордлого зэрэг аюулт үзэгдэл, ослын үед хүн амыг богино хугацаанд аюулгүй байршилд нүүн шилжүүлэх дадлага сургуулийг Өвөрхангай, Баянхонгор,

Хөвсгөл, Өмнөговь, Говь-Алтай, Баян-Өлгий, Дорноговь зэрэг 7 аймгийн төвд зохион байгуулахад 156.000 гаруй иргэд хамрагдсан байна.

Гамшгаас хамгаалах команд штабын сургууль

Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийг нийт 24 аймагт зохион байгуулахад гамшгаас хамгаалах орон нутгийн алба 288, сумын ерөнхий зориулалтын мэргэжлийн анги 360, тусгай зориулалтын мэргэжлийн анги 768, тэдгээрийн томилгоот 61.200 гаруй ажилтан, албан хаагч, 4548 автомашин, 85.600 төрлийн багаж, техник хэрэгсэлтэй оролцсон байна.

Гамшгаас хамгаалах команд штабын сургуулийн хүрээнд аймаг, сум, гамшгаас хамгаалах орон нутгийн алба, мэргэжлийн анги, хуулийн этгээдийн нийт 4100 гаруй гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөнд тодотгол хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан.

Гамшгаас хамгаалах ангиллын сургалт

Гамшгаас хамгаалах тухай хуулиар гамшгаас хамгаалах сургалтыг удирдах албан тушаалтны, онцгой байдлын байгууллагын, оюутан, сурагч, сургуульд элсэхийн өмнөх насны хүүхдийн төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийн албан тушаалтан, ажилтны, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн, иргэний гэж ангилсны дагуу Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/130 дугаар тушаалаар “Удирдах албан тушаалтан”, “Мэргэжлийн анги”, “Ажилтан, албан хаагч”, “Сайн дурынхан”, “Иргэн”-ий гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж ажиллаж байна. Үүнд:

Жилд дунджаар удирдах албан тушаалтны сургалтыг 270 удаа, мэргэжлийн ангийн сургалтыг 450 удаа, ажилтан албан хаагчдын сургалтыг 1700 удаа, иргэдийн сургалтыг 1200 орчим удаа зохион байгуулж 420.000 гаруй иргэн, ажилтан, албан тушаалтныг хамруулсан нь сүүлийн 13 жилд харицуулахад онцгой байдлын алба нь давхардсан тоогоор 4.620.000 орчим хүнд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтыг зохион байгуулж ирсэн байна.

“Гамшгаас хамгаалах менежмент” сургалт:

Их, дээд сургууль, коллежийн оюутнуудад гамшгаас хамгаалах боловсрол олгох чиглэлээр салбарын яамтай хамтран ажиллаж байна.

-БСШУСайдын 2017 оны 08 дугаар сарын 03-ны өдрийн А/103 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах менежмент” хичээлийг 1 багц цагаар их, дээд сургууль, коллежид заавал судлах хичээлийн жагсаалтад оруулж, сурах бичгээр хангаж, сургалт хэвийн явагдаж байна.

-ХНХЯ-тай хамтран политехник коллеж, МСҮТ-ийн оюутнуудад 54, 36 цагаар “Гамшгаас хамгаалах мэдлэг” олгох сургалтыг явуулахаар агуулга, хөтөлбөрийг боловсруулж, батлуулан тус яамны сайдын 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/138 дугаар тушаалаар “Гамшгаас хамгаалах мэдлэг” олгох хичээлийг заавал судлах хичээлийн жагсаалтад оруулж, сургагч багш нарыг бэлтгэж, сурах бичиг, гарын авлагаар хангасан.

“Аюулгүй амьдрах ухаан” сургалт:

Сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсролын сургуулийн хүүхдүүдэд гамшгаас хамгаалах боловсрол олгох асуудлыг цөм хөтөлбөрт тусгах чиглэлээр БСШУСЯ, Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институттэй хамтран ажиллаж, СӨБ, ЕБС-ийн цөм хөтөлбөрт оруулах “Аюулгүй амьдрах ухааны үндэс” хичээлийн хөтөлбөрийн агуулга, сургалтын гарын авлагыг боловсруулж, олон нийтээр хэлэлцүүлэн санал авч, батлуулахад бэлэн болгосон.

Өсвөрийн аврагч тэмцээн:

Сурагчдын бие бялдрыг хөгжүүлэх, аюулгүй амьдрах арга ухаанд сургах, тэсвэр хатуужил хүнлэг энэрэнгүй хүмүүжил олгох, онцгой байдлын албаны үйл ажиллагааг сурталчлан таниулах, аюул, ослын үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалахад сургаж дадлагажуулах зорилгоор ерөнхий борловсролын сургуулиудыг түшиглэн “Өсвөрийн аврагч” бүлгүүдийг байгуулж, 2013 оноос эхлэн жил бүр сум, дүүрэг, аймаг, нийслэлийн түвшинд “Өсвөрийн аврагч” тэмцээнийг уламжлал болгон зохион байгуулж байна. 2017 оны байдлаар 275 “Өсвөрийн аврагч” бүлэгт 6000 гаруй хүүхэд нэгдэж, гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд суралцан бусад хүүхдүүдэд нөлөөллийн ажлыг явуулж байна.

Сургагч багш бэлтгэх:

Гамшгаас хамгаалах тухай хууль, Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого, Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд 21 аймаг, 9 дүүрэгт “Сайн дурын бүлэг” байгуулж, тэднийг сайн дурын идэвхитэнээр сургаж бэлтгэсэн. Цаашид 2018 оны 1 дүгээр улиралд эдгээр сайн дурын идэвхитэнийг “Сургагч багш”-аар бэлтгэж, иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах сургалт явуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Өрхийн гамшгаас хамгаалах сургалтын багц боловсруулах:

Иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг, чадвар олгох зорилтын хүрээнд газар хөдлөлт, химийн бодис, ахуйн гал түймэр, хүчтэй цасан болон шороон шуурга, аянга цахилгаан, халдварт өвчин, ой, хээрийн түймэр, үер, ган, зуд, уур амьсгалын өөрчлөлт, өрхийн эрсдэлийн үнэлгээ, өрхийн гамшгаас хамгаалах төлөвлөлт сэдвүүдээр “Бэлэн бай” сургалтын багц хичээлүүдийг боловсруулж, төв орон нутгийн Онцгой байдлын газар, хэлтэс, анги байгууллагын сургалт хариуцсан ажилтнуудыг “Сургагч багш”-аар бэлтгээд байна. Цаашид аймаг, дүүрэгт бэлтгэгдсэн сайн дурын идэвхитэнийг “Сургагч багш”-аар бэлтгэхээр төлөвлөн ажиллаж байна.

Засгийн газрын тогтоолын хүрээнд зохион байгуулсан арга хэмжээ:

-Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 339, 340 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохиогоор ажиллах дадлага сургуулийг 2012 оноос эхлэн жил бүрийн 3 дугаар сарын 4 дэх 7 хоногийн “Пүрэв” гаригт улс орон даяар зохион байгуулж байна. Энэхүү бүх нийтийн дадлага сургуульд давхардсан тоогоор 1900 гамшгаас хамгаалах улсын болон орон нутгийн алба, 3800 мэргэжлийн анги, 17000 гаруй төр захиргааны болон аж ахуйн нэгж, байгууллага оролцож, 4.300.000 гаруй хүн хамрагдсан байна. Мөн 2017 оноос эхлэн Монгол Улсын Засгийн газрын 67 дугаар тогтоолыг

хэрэгжүүлж, “Газар хөдлөлтийн гамшгийг даван туулах үндэсний чадавхыг сайжруулах нь”, “Газар хөдлөлтийн үед ямар арга хэмжээ авах вэ?” лекцийг бэлтгэж, МҮОНРТ-ээр олон нийтэд хүргэсэн.

Гамшгийн эрсдэлийг бууруулах олон улсын өдөр:

НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2009 оны 64/200 дугаар шийдвэрийн дагуу жил бүрийн 10 дугаар сарын 13-ны өдрийг “Гамшгийн эрсдэлийг бууруулах Олон Улсын өдөр” болгон тэмдэглэдэг уламжлалтай бөгөөд Монгол Улс 8 удаа улс орон даяар тэмдэглэн өнгөрүүлжээ. Энэхүү өдрийн хүрээнд иргэд, олон нийтийг гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд сургаж дадлагажуулах, тэдэнд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэлтэй гамшгийг хохирол багатай даван туулахын тулд дасан зохицох чадвар эзэмшүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлж, танхимын сургалт, биеэр гүйцэтгэх дадлага сургууль, АХА тэмцээн, илтгэл, ЭССЭ бичлэг, зургийн уралдааныг тус тус зохион байгуулж ажилласан.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, олон нийттэй харилцах чиглэлээр:

Гамшгаас урьдчилан сэргийлэх, сургалт, сурталчилгаа

Гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг иргэдэд тогтмол, шуурхай, цаг алдалгүй хүргэх, сэрэмжлүүлэх, албаны үйл ажиллагаа, онцлогийг олон нийтэд сурталчлах чиглэлээр төвийн 29 телевиз, 21 сонин, 35 цахим хуудас, 9 FM радио зэрэг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж байна.

Дээрхи хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран жилд дунджаар 1600 гаар тооцоход 2004-2017 он буюу 14 жилийн хугацаанд 23 мянга орчим удаагийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.

Мөн байгалийн гамшиг, аюулт үзэгдэл ослоос урьдчилан сэргийлэх телевизийн 20-30 секундын сэрэмжлүүлэг шторкийг жилд дунджаар 600 удаа буюу, 14 жилийн хугацаанд нийт 8400 гаруй удаа 70 гаруй цагийн шторкийг эфирт нэвтрүүлэн ажилласан байна.

“Аврагч” студи

Гамшгийн эрсдэлийг бууруулах, иргэдийн болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах дадал эзэмшүүлэх, гамшгаас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн төслийн 36,4 сая төгрөгийн санхүүжилтээр ОБЕГ-ын дэргэд “Аврагч” студийг байгуулав.

“Аврагч” студийг түшиглэн иргэдийн гамшгаас урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, албаны үйл ажиллагаа, онцлогийг сурталчлах зорилгоор 2014 оноос 14 хоног тутамд 15 минутаар “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгийг бэлтгэн

МҮОНТ-ийн 1, 2 дугаар суваг, UBS, Өлзий зэрэг телевизээр 2014 оноос эхлэн нийт 72 дугаар буюу 24 цагийн нэвтрүүлгийг үзэгчдэд хүргэн ажилласан.

Тус нэвтрүүлгийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах эрх ашгийг хүндэтгэх зорилгоор дохионы хэлтэйгээр хүргэж байна.

“Онцгой мэдээ” сонин

Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаа, алба хаагчдын ажил, мэргэжлийн онцлогийг олон нийтэд сурталчлан таниулах, салбарын хэмжээнд шилдэг, тэргүүний алба хаагч, анги, салбарыг алдаршуулах, сайн туршлагыг түгээх, гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн мэдлэг ойлголтыг дээшлүүлж, чадавхи, оролцоог хангах зорилгоор 2015 оноос эхлэн 14 хоног тутмын “Онцгой мэдээ” сонинг эрхлэн гаргаж байна. Нийт 58 дугаар уншигчдад хүрсэн.

www.nema.gov.mn цахим хуудас

Байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй, ил тод сурталчлан ажиллах зорилтын хүрээнд www.nema.gov.mn цахим хуудсыг 2013 оноос идэвхитэй ажиллуулж 2016 оноос тус цахим хуудасны агуулга, бүтцийг өөрчлөн шинэчлэх ажлыг хийж гүйцэтгэн шинэ өнгө төрхтэйгээр олон нийтэд хүрч байна.

2016 оноос хойш нийт 2800 гаруй удаагийн мэдээ, мэдээлэл байршуулсан. Энэ хугацаанд нийт 985 мянга гаруй хүн цахим хуудсанд хандсан байна. Өдөрт тогтмол 1500-3500, сард 30-50 мянган хүн хандаж мэдээ, мэдээлэл авч байна.

Байгууллагын сайтыг хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчдийн нэгдсэн группт холбуулсан нь хэвлэл мэдээллийн байгууллага, сэтгүүлчид Онцгой байдлын албаны үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг шууд, цаг алдалгүй шуурхай авах боломж бүрдсэн. Ингэснээр өдөрт тогтмол 20 гаруй мэдээллийн сайт, сонингоор дамжуулан Онцгой байдлын албатай холбоотой мэдээлэл иргэд, олон нийтэд хүрч байна.

Гамшгаас урьдчилан сэргийлэх гарын авлага, сурталчилгааны материал

- Иргэдийн болзошгүй байгалийн гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, өөрийгөө болон бусдыг авран хамгаалах, бусдад туслах дадал, хэвшлийг эзэмшүүлэх, гамшгаас хамгаалах ардын арга уламжлал, арга, туршлагыг түгээхэд чиглэсэн гамшгаас урьдчилан сэргийлэх гарын авлага, сурталчилгааны материалыг монгол оронд тохиолддог үер, усны осол, хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, малын халдварт болон гоц халдварт өвчин, газар

хөдлөлт зэрэг 10 гаруй төрлүүдээр бэлтгэн хэвлүүлж сургалт, сурталчилгаанд ашиглаж байна. Жилд дунджаар 15 мянга, 10 жилийн хугацаанд 150 орчим мянган ширхэг хэвлэмэл материалыг иргэдэд тарааж байна.

- Монгол Улсын Шадар сайдын 2013 онд батлагдсан “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний дэд хөтөлбөр”-ийн хүрээнд ОБЕГ, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Дэлхийн Зөн Монгол олон улсын байгууллагаас зохион байгуулсан иргэд, олон нийтэд чиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт, сурталчилгааны материал болох “Аврагч Мазаалайн зөвлөмж” гарын авлага, брошур, зурагт хуудас, телевизийн анимешн шторк бэлтгэн олны хүртээл болгоод байна.

- “Олон нийтэд тулгуурласан гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний дэд хөтөлбөр”-ийн хүрээнд Дэлхийн зөн-Монгол ОУБ-тай хамтран “Аврагч мазаалайн зөвлөмж” сэдэвт аюулт үзэгдэл, ослын 9 төрлөөр тус бүр 1 минутын хугацаатай телевизийн цуврал шторк, “Аюулгүй сургууль”, “Нэг жилийн хугацаанд бид юу туулдаг вэ” инфо графикийн шторкийг тус тус бэлтгэн гаргаж төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлан ажиллаж байна.

- НҮБХХ-ийн төслийн санхүүжилтээр “Галын аюулаас урьдчилан сэргийлэх ардын уламжлалт арга ухаан”, “Салхи шуурганы аюулыг танин мэдэх, урьдчилан сэргийлэх арга ухаан”, “Газар, тэнгэрээ аргадах нь Монголын уламжлалт ухаан”, “Гол усаа хайрлан хамгаалъя” цуврал хичээлүүд, Нийслэлийн Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран бэлтгэсэн анхны тусламжийн цуврал хичээлүүдийг DVD хэлбэрээр хэвлүүлсэн. Эдгээр хичээлийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулан дохионы хэлээр орчуулуулан сургалт, сурталчилгаанд ашиглаж байна.

Японы Хүүхдийг ивээх сангаас зарласан “Гамшгийн эрсдэлийг бууруулах зорилгоор олон нийтэд чиглэсэн нөлөөллийн багц боловсруулах удирдамж”-ийн хүрээнд ой, хээрийн түймэр, үер, гол мөрөн, нуурын усны осол, хүчтэй цасан болон шороон шуурга, хүн, малын гоц халдварт өвчин, газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр 30 секундын телевизийн шторк, 5 минутын хүүхдийн видео киног тус тус хийж, төв, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчлан ажиллаж байна.

Хэвлэх хэсэг

2017 онд Гамшгаас урьдчилан сэргийлэх газрын Олон нийттэй харилцах төвд Монголын Улаан загалмай нийгэмлэгийн санхүүжилтээр орчин үеийн хэвлэх машинтай болсноор Онцгой байдлын албаны хэмжээнд, гамшгаас урьдчилан сэргийлэх

ухуулга, сурталчилгааны материал, зурагт хуудас, брошур, танилцуулга, өргөмжлөл, урилга, мэндчилгээ, нэрийн хуудас зэрэг хэвлэлийн ажлыг гүйцэтгэх боломжтой болсон.

“Нарны жим” олон ангит уран сайхны кино

Монгол Улсын Шадар сайдын санаачлагаар Онцгой байдлын ерөнхий газраас Гамшгаас хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийг сурталчлах, тус байгууллагын үйл ажиллагаа, албан хаагчдын ажил, мэргэжлийн онцлогийг олон нийтэд таниулан ойлгуулах, иргэдэд эх орноо хайрлан хамгаалах, гамшиг осолгүй Монголын төлөө өөрийн оруулах хувь нэмрийг ухамсарлан ойлгуулах үзлийг төлөвшүүлэх, иргэдэд гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх мэдлэг, боловсролыг олгох, соён гэгээрүүлэх зорилгоор Монголын үндэсний олон нийтийн телевиз, Гамшиг, гал түймрээс хамгаалах Монголын нийгэмлэгтэй хамтран “Нарны жим” 50 ангит уран сайхны кино бүтээв.

Түүхэн ном, баримтат кино

Онцгой байдлын байгууллагын түүх, үйл ажиллагаа, албаны онцлогийг харуулсан “Ариун үйлсийн манаанд”, “Сүлдэнд мөнхөрсөн эр зоригийн алба” баримтат кино, “Алдраа дуурсгасан 10 жил”, “Иргэний хамгаалалтын түүхэн замнал” номын цомог, “Онцгой байдлын алба”, “Онцгой байдлын алба-энхийг сахиулах ажиллагаанд” зурган цомгуудыг гаргав.

Онцгой байдлын албаны Гурван үеийн чуулга уулзалт

Онцгой байдлын байгууллагын залгамж чанарыг бэхжүүлэх, ахмад үеийнхний туршлага, мэдлэгийг залуу, хойч үедээ өвлүүлэх, харилцан туршлага судлах, албаны хэмжээнд цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох зорилгын хүрээнд Онцгой байдлын албаны Гурван үеийн чуулга уулзалтыг 2008, 2013, 2017 онуудад зохион байгуулав.

Чуулга уулзалтад оролцогчдын санал, дэвшүүлсэн зорилтыг цаашид ажил хэрэг болгох үүднээс чуулга уулзалтад оролцогч ахмад, дунд, залуу үеийн төлөөлөл зөвлөмж гаргадаг нь Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаа, ирээдүйн зорилтыг тодорхойлоход чухал ач холбогдолтой үйл явдал болдог.

АЙМГУУДАД ГАМШГААС ХАМГААЛАХ ИЖ БҮРЭН БОЛОН КОМАНД ШТАБЫН
СУРГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛСАН ХУГАЦАА, ОН

д/д	Аймгийн нэр	Гамшгаас хамгаалах ИБ, КШСургууль зохион байгуулагдсан он	
		Иж бүрэн	Команд штаб
1	Архангай	2005, 2012	2017
2	Баянхонгор	2015	2011
3	Баян-Өлгий	2017	2004, 2011
4	Булган	2013	2006
5	Говь-Алтай	2009, 2017	2013
6	Говьсүмбэр	2010	2014
7	Дархан-Уул	2010	2015
8	Дорноговь	2017	2011
9	Дорнод	2010	2015
10	Дундговь	2014	2009
11	Завхан	2014	2006
12	Орхон	2011	2016
13	Өвөрхангай	2015	2010
14	Өмнөговь	2006	2017
15	Сүхбаатар	2006	2013
16	Сэлэнгэ	2010	2015

17	Төв	2009	2013
18	Увс	2007	2012
19	Хөвсгөл	2017	2011
20	Ховд	2014	2010
21	Хэнтий	2013	2007